Тагнуулын ерөнхий газрын 2026 оны 01 дүгээр сарын 15-ний өдрийн ТЕГ/01/20 дугаар албан бичгийн хавсралт

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ
“ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ”

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо	Хувийн жин
1	2	3		4	5	6
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн батлалсан эсэх		1	1	10
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх		1	0	0
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх	0.5	0.5	5
			Соён гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал	0.5	0.5	5
			Ёс зүйн зөрчлийн мэдүүлэг гаргасан байдал	0.5	0	0
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал	0.5	0	0
Хэсгийн оноо				**4**	**2**	**20**
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх (гарсан дүгнэлтийн хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо)		1	1	10
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал		1	0	0
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал		1	1	10
Хэсгийн оноо				**3**	**2**	**25**
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал		1	1	10
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал (Гомдол ирээгүй бол 1 оноо авна, нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын хувийн жингээр тооцно)		1	1	10
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал		1	0	0
Хэсгийн оноо				**3**	**2**	**20**
Үнэлгээний нийт оноо, хувь				**10**	**6**	**60**

---o0o---

БАЙГУУЛЛГЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
“ТАЙЛАНГИЙН МАЯГТ”

НЭГ. Товч танилцуулга
Тагнуулын ерөнхий газраас 2025 онд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг зохион байгуулж, дэд хорооны дарга, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг тухай бүр шийдвэрлэж ажилласан бөгөөд Тагнуулын ерөнхий газрын албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөг баталж, сургалт, хэлэлцүүлэг, нөлөөллийн аян, едерлөг зэргийг нийт албан хаагчдын дунд зохион байгуулсан. Тайлант хугацаанд тус газрын Ёс зүйн дэд хороо 12 албан хаагчид холбогдох асуудлыг хэлэлцэж, 8 дүгнэлт гаргаж, Тагнуулын ерөнхий газрын даргын тушаалаар 7 албан хаагчид сахилгын шийтгэл оногдуулж, 1 албан хаагч Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 17.2.2-т заасан өөрийн хүсэлтээр албанаас чөлөөлөгдөх ёс зүйн хариуцлага хүлээсэн. Тагнуулын байгууллагын тухай хуульд тагнуулын ажилтанд тавих ёс зүйн тусгай шаардлагыг тодорхойлсон бөгөөд Засгийн газрын 2009 оны 256 дугаар тогтоолоор баталсан “Тагнуулын ажилтны сахилгын дүрэм”-ээр тагнуулын ажилтан ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд ёс зүйн хорооны дүгнэлтийг үндэслэн тухайн ажилтанд сахилгын шийтгэл оногдуулах зохицуулалттай тул дээрх албан хаагчдад сахилгын шийтгэл оногдуулсан болно.
ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт:
Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд Тагнуулын ерөнхий газрын албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөг баталж дараах арга хэмжээг авч ажиллав: - Ёс зүйн хороотой хамтран тагнуулын байгууллагын нийт албан хаагчдад “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, түүнд холбогдох дүрэм, журам” сэдэвт сургалт; - Тагнуулын ерөнхий газрын төв, орон нутаг дахь салбар, нэгжийн удирдах албан тушаалтнуудад “Удирдах албан тушаалтны ёс зүйн манлайлал” сэдэвт сургалт; - Төв, орон нутаг дахь салбар, нэгжийн албан хаагчдад байгууллагын хэмжээнд гарч буй ёс зүйн зөрчил түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар ойлголт өгөх зорилгоор тодорхой тохиолдол, баримтад үндэслэсэн сургалт; - Үндэсний тагнуулын их сургуулийн сонсогч, ТЕГ-т анх томилогдсон албан хаагчдад “Тагнуулын байгууллагын албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ” сэдэвт сургалт /тухай бүр/; - Тагнуулын байгууллагын хэмжээнд “Би ёс зүйтэй албан хаагч” сэдэвт нөлөөллийн аян; - “Урмаар тэтгэе” уриалгын дор албан хаагчдын ажиллах идэвхийг сэргээх дэмжих зорилгоор едерлөг, талархлын захидал илгээх аян; - Хамт олны уур амьсгалыг сайжруулах зорилгоор хурал, уулзалтыг хэвшмэл бус, шинэлэг (зангиагүй хурал, кофены завсарлага, номын хэлэлцүүлэг гэх мэт) арга барилаар зохион байгуулах нөлөөллийн ажил, арга хэмжээ; - Гэр бүлийн харилцаа, хөгжлийн чиглэлээр мэргэжлийн байгууллага, судлаачидтай хамтран 8 удаагийн сургалтыг зохион байгуулж Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллав.
2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд Тагнуулын ерөнхий газрын албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжилтэд тухай бүр хяналт тавьж ажиллав.

Албан хаагчдын ёс зүй, сахилгын зөрчил гаргасан байдалтай нь уялдуулан албан даалгавар гаргаж, холбогдох салбар, нэгжид тухай бүр сэрэмжлүүлэг хүргүүлж, биелэлтэд хяналт тавьж ажиллав.

Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Тагнуулын ерөнхий газрын Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг тухай бүр шийдвэрлэн ажиллав.

Ахмад ажилтнуудын ажлын туршлага, ажил үйлс, алдаа оноо болон сургамжийг залуу ажилтнуудад таниулж, тогтвор суурьшилтай ажиллах, байгууллагаараа бахархах үнэт зүйл, соёлыг төлөвшүүлэх зорилгоор тагнуулын байгууллагын 3 үеийн дурсамж контент бүтээв.

2.3.Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа

Ёс зүйн дэд хороо тайлант хугацаанд 6 удаа хуралдаж, 12 албан хаагчид холбогдох асуудлыг авч хэлэлцэн 8 дүгнэлт гаргаж, ТЕГ-ын даргын тушаалаар 7 албан хаагч тагнуулын ажилтанд тавигдах тусгайлсан шаардлагыг буюу мэргэжлийн ёс зүй зөрчсөн асуудалд сахилгын шийтгэл оногдуулж, 1 албан хаагч Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 17.2.2-т заасан өөрийн хүсэлтээр албанаас чөлөөлөгдөх ёс зүйн хариуцлага хүлээсэн байна.

ТЕГ-ын Ёс зүйн дэд хорооноос тагнуулын байгууллагын албан хаагчийн ёс зүйн асуудлыг хянан шийдвэрлэх явцад илэрч буй зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгах, албан хаагчдын ёс зүй, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, үйл ажиллагааны процессын сахилгыг сайжруулах зорилгоор Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3 дахь заалтыг үндэслэн төв, орон нутаг дахь салбар, нэгжийн дарга, албан хаагч нарт 2 удаагийн зөвлөмжийг боловсруулж хүргүүлсэн.

Тагнуулын байгууллагын албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд нийт албан хаагчдын сүлжээнд 2 удаа постер бэлтгэж, нийтэлсэн бөгөөд төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор тухай бүр сургалт, нөлөөллийн аяныг зохион байгуулж ажиллав.

Гарсан үр дүн, ололт, амжилт:	Бэрхшээл:
	-
Санал:	

Шалгах хэсэг:

☐ “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.

☐ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.

☐ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан

Тагнуулын ерөнхий газрын дарга /П.Одонбаатар/
/Албан тушаал/ /Гарын үсэг/ /Гарын үсгийн тайлал/

Ёс зүйн дэд хорооны дарга

Тэргүүн дэд дарга /А.Бат-Эрдэнэ/
/Албан тушаал/ /Гарын үсэг/ /Гарын үсгийн тайлал/

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга

Хэлтсийн дарга /Б.Батмөнх/
/Албан тушаал/ /Гарын үсэг/ /Гарын үсгийн тайлал/

Огноо: 2026 оны 01 сарын 14